

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Нэг. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

“Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан нийт зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын саналыг нэгтгэн сангийн яаманд хүргүүлж Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг батлах, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай” 29 дүгээр тушаалаар шийдвэрлүүлсэн.

Тус хөтөлбөрийн дагуу ГЕГ-ын даргын 2023.02.16-ны өдрийн А/32 тоот тушаалаар “Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, орон тоо”- /ГЕГ-ын 22, харъяа газар, хороо-18/-г шинэчлэн баталсан.

Энэ онд нийт орон тоо ТТ-1825, ТҮ-512 буюу 2337 баталснаас тайлант онд ТТ-1410, ТҮ-460 буюу 1870 албан хаагч ажиллаж байна. Үүнээс удирдах албан тушаалд 81, гүйцэтгэх албан тушаалд 1789 албан хаагч ажиллаж байна. Мөн энэ онд шинээр ажилд орсон-234, суралцах болон эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас чөлөөлж нөөцөд бүртгэсэн-19, өндөр насны тэтгэвэрт-27, хүүхэд асрах чөлөө-75, нас барсан-7, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн-66, гаалийн албанаас халагдсан-3 тус тус байна.

Шинэчлэн баталсан бүтцийн дагуу гаалийн байгууллагын 2019 оноос батлан мөрдөж байсан албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулан 140 ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлуулсан.

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын дагуу Гаалийн байгууллагын 1670 албан хаагчдын үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэв, болон бусад нэмэгдлийн тогтоон шинэчилсэн.

Мөн 2023 оны 06 сарын 21-ний өдрийн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 241 дүгээр тогтоолын дагуу гаалийн байгууллагын 1777 албан хаагчийн үндсэн цалин болон бусад нэмэгдлийг дахин шинэчилсэн.

Дээрх 2 удаагийн шийдвэрээр албан хаагчдын үндсэн цалин, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэв, болон бусад нэмэгдлийг шинэчлэн тогтоож үндсэн цалинг 140-410 мянган төгрөгөөр нэмэгдүүллээ.

Гаалийн лабораторид ажиллагсдын хөдөлмөрийг “хөдөлмөрийн хүнд” нөхцөлд тооцуулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2014 оны 77 дугаар тушаалаар батлагдсан Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтын 3 дугаар зүйлд хамаарах гаалийн лабораторийн 54 албан хаагчийн нэмэгдлийг олгох шийдвэр гаргуулсан.

Засгийн газрын “5 Ш” ажиллагааны нэг болох “Шүүр” арга хэмжээнд Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хангаагүй, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил,

мэргэшил, ур чадварын шаардлагыг хангаагүй журам зөрчин томилогдсон нийт 149 албан хаагч байгааг тогтоосон. /ерөнхий шалгалт өгөөгүй -61, тусгай шалгалт өгөөгүй - 88/. Тусгай шалгалтыг 2 удаа зохион байгуулснаар 107 албан хаагч буюу 71.8 хувийг буцаан томилж хууль ёсны томилгоотой болгов.

Сангийн яамны дэргэдэх Салбар зөвлөл байсныг 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор ТАЗ-ийн ГЕГ-ын дэргэдэх “Салбар зөвлөл” байгуулав.

Тус салбар байгуулагдсанаар төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж гаалийн байгууллагад үүссэн сул орон тоог нөхөн хангах ажлыг шуурхай явуулах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэшсэн, чадварлаг, хүний нөөцийг бүрдүүлэх боломж бүрдлээ.

Энэ оны эхээр 459 сул орон тоо байсан. Салбар зөвлөлөөс явуулсан 2 удаагийн тусгай шалгалтаар 234 буюу 50 хувийг нөхсөн. /үүний 76% нь орон нутагт, 24% нь Улаанбаатар хотын бүсэд томилогдсон байна.

Мөн удирдлагын зүгээс гаалийн байгууллагын хүний нөөцийн нөхцөл байдлыг тодорхойлон, түүнд үндэслэн шаардлагатай арга хэмжээг авахаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаа.Үүнд:

Төрийн албаны зөвлөлийн “Зөвлөн туслах ажлын хэсэг”-ийг урьж ГЕГ-т 21 хоног ажилласан. Зөвлөн туслах баг нь гаалийн байгууллагын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэр, бичиг баримтууд, 1445 албан хаагчдын хувийн хэргийг нэг бүрчлэн үзэж танилцахын зэрэгцээ, ажилд авах, томилох, дэвшүүлэн томилох, сэлгэн ажиллуулсан байдал зэрэг үйл ажиллагаанд зөвөлгөө ажиллаа. Тухайлбал:

Нийт байгууллагын хэмжээнд Гаалийн захиргаа дотоод ажлын системд хувийн хэргийн мэдээллээ шинэчлэн оруулах, хувийн хэрэгтээ баяжилт хийх, ТАЗ-ын 2022 оны 600 дугаар тогтоолын 2-р хавсралт Төрийн албан хаагчийн анкетыг шинэчлэх, албан хаагчийг гэмт хэрэгт холбогдолгүй, ял шийтгэлгүй талаарх тодорхойлолтыг авч хувийн хэрэгт шинээр бүрдүүлж хийв.

Зөвлөн туслах багт албан хаагчийн хувийн хэргийн одоогийн байгөө нөхцлийг шинэчлэх, стандарт хангасан тусгайлсан өрөө гаргах, нягтаршуулсан шүүгээ хавтасны судалгааг хийж, хэрэгцээ шаардлагыг танилцуулав.

Мөн гаалийн байгууллагын захиргаа, хүний нөөц, удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, ажлын ачааллыг тооцох, ажлын байрны зураг авалт хийх зорилгоор мэргэжлийн байгууллагуудыг судалж, “Монголын хүний нөөцийн институт”-ыг сонгон хамтран ажиллах гэрээ байгуулан, туслан ажиллах дэд ажлын хэсгийг томилон ажиллуулсан. Энэ хүрээнд Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар, Замын-Үүд, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газруудтай гэрээ байгуулан үйл ажиллагааны ажлын зураг авалт, асуумж бөглөх, албан хаагчидтай ярилцлага хийх замаар дүгнэлт зөвлөмж гарган ажиллаа.

Дэд ажлын хэсгийн гишүүдээс ХШУДАГ-ын ГУБ С.Нямсүрэн, ХНХ-ийн ГУБ Б.Батчимэг нар нь ГЕГ-ын даргын удирдамжаар энэ оны 05 дугаар сарын 21-25 хооронд МХНА-ийн зөвлөх ажилтны хамт Замын-Үүд дэх гаалийн газрын бүтэц, зохион

байгуулалт нь гаалийн хяналт шалгалт бүрдүүлэлт, хорио цээрийн технологи ажиллагааны бодит байдалд зураг авалт хийж үүсэж байгаа асуудалд дүгнэлт гарган хамтран ажиллаа.

Дүгнэлтэд байгууллагын бүтэц, мэдээллийн урсгал, программын ашиглалт, төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээ, асуудлын эрэмбэ дараалал, албан хаагчдын хандлага, ажлын уялдаа холбоог зураглан гаргахын зэрэгцээ захиргаа хүний нөөцийн чиглэлээр засаж сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг гаргасныг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

ГЕГ-ын удирдлагын зүгээс Улаанбаатар, Замын үүд дэх гаалийн газрын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үүрэг бүхий Ажлын хэсэг томилон ажиллуулав. Энэ ажлын хүрээнд дараах дүгнэлтийг гаргасан.

-Улаанбаатар гаалийн газар 2022 онд баталсан орон тоон илүү хэтрүүлж ажилласан, цалингийн санд хүндрэл үүсгэсэн байна, албан хаагчдад сахилга хариуцлага тооцож ажиллаагүй, цаг ашиглалтын хяналт хангалтгүй буюу чөлөө өвчтэй хүмүүст цалин өгсөн, захиргааны чиглэлийн ажил дутагдалтай үнэлгээг ажлын хэсэг холбогдох үзүүлэлтээр тогтоож ажилласан.

-Замын-Үүд дэх гаалийн газар нь албан хаагчдыг сургах үйл ажиллагаанд үр дүн тооцдоггүй, ёс зүй хандлага, авлигын эсрэг бууруулах ажил арга хэмжээ үр дүнгүй хийсвэр, орон тооны санал нөхөн хангалтаа шийдвэрлүүлээгүй зэрэг дутагдлыг засах хугацаатай үүрэг өгсөн.

Хүний нөөцийн хэлтсээс “Ахмадын байгууллага, ахмадуудтай хамтран ажиллах”, “Ахмадын сан” байгуулж ажиллах журам-ыг шинээр боловсруулж ГЕГ-ын даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/290 тушаалаар баталж мөрдөж байна.

Ковидын үеийн хуулийн хэрэгжилт дуусгавар болсонтой холбогдуулаад хорио цээрийн чиглэлийн 7 албан хаагчийг ажлаас чөлөөлөх байсныг тусгай шалгалт өгөх хүртэл ажлын ачаалал, нарийн мэргэжлийн хэрэгцээг шаардлагыг харгалзан түр томилох шийдвэр гаргуулж ажиллав.

Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхийг эрмэлзэж гаалийн байгууллагын 8 албан хаагчийг өмнөх ажлын байранд зөвшилцөн, эгүүлэн томилж шийдвэрлүүлэв.

Төрийн албаны хуулийн 27 дугаар зүйлд албан хаагчийг ажлын шаардлагаар төрийн байгууллага хооронд 14 албан хаагчийг шилжүүлэн авч томиллоо.

Төрийн албаны тухай хуул тогтоомж болон шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхийг эрмэлзэж гаалийн байгууллагаас халагдсан, чөлөөлөгдсөн 8 албан хаагчийг зөвшилцөн өмнөх ажлын байранд эгүүлэн томилов.

Хоёр. ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР:

Гаалийн байгууллагын хүний нөөцийн удирдлагын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай “Нээлттэй хэлэлцүүлэг”-ийг энэ оны 04 дүгээр сарын 20-ны өдөр танхимаар болон цахимаар ГЕГ -ын нэгж болон дэргэдэх байгууллага, харьяа 18 гаалийн газар, хороог хамруулан зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгээс гарсан нэгдсэн санал дээр тулгуурлан асуудлын гарц шийдэл олох замаар “Ажлын хэсэг” томилж, сэлгэн ажиллуулах өмнөх журмыг сайжруулах, цахим хэлбэрт шилжүүлж шинэ арга туршилтыг нэвтрүүлэхээр “Гаалийн улсын байцаагчийг шилжүүлэн ажиллуулах журам”, “ГУБ-ыг шилжүүлэн ажиллуулах журмын аргачлал”-ийг энэ оны 06 дугаар сарын 14-ны ГЕГ-ын даргын А/367 тушаалаар баталлаа. Энэ журам батлагдсанаар албан хаагчдыг сэлгэн ажиллуулах эрх зүйн баримт бичгийг сайжруулж, цахим шинэ аргачлал хэрэгжих боломж бүрдсэн.

Уг журмын төслийг нийт албан хаагчдад 2 удаа танилцуулж 300 гаруй саналыг хүлээн авч нэгтгэн Захиргааны зөвлөлийн хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлсэн, журмын аргачлал бүхий бодлогын даалгаврыг Мэдээлэл технологийн газарт хүлээлгэн өгсөн болон журмыг нийт албан хаагчдад таниулах, ойлгуулах ажлыг хийв.

Цахим аргачлалыг хэрэгжүүлэхэд газар дээр нь туршиж нөхцөл байдлыг тодорхойлох зорилго бүхий 2 ажлын хэсэг Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газруудад СЕРП-ын хувийн хэргийн цахим сангийн баяжилтын явц болон тухайн бүсэд тасралтгүй ажилласан жилийн жагсаалтыг гарган оноогоор эрэмбэлэн программыг туршиж ажиллав.

Уг ажлыг хийж гүйцэтгэх албан тушаалтан болох 18 газар, хороодод Захиргаа, хүний нөөц хариуцсан ГУАБ-15, ГУБ 28 батлагдсанаас ГУАБ 9, ГУБ 14 ажиллаж байгаа буюу 50% нь томилогдоогүй байгаа нь захиргаа хүний нөөцийн ажилд нөлөөлж байна гэж үзсэн.

Гаалийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр Дотоод хэргийн Их сургуультай санамж бичиг байгуулж, МУИС-ийн Эдийн засаг бизнесийн сургууль, ХААИС-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлж үе шаттайгаар ажиллаж байна.

Гаалийн байгууллагын алба хаагчийн сургалт, хөгжил, гүйцэтгэлийг сайжруулах, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, амь насыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, ажиллах таатай орчноор хангах, хүний нөөцийн хөгжлийн дунд хугацааны Хөтөлбөрийг боловсрууллаа.

Гурав. ХҮНИЙ НӨӨЦИЙН НӨХӨН ХАНГАЛТЫН ТАЛААР:

ТАЗ-ийн Салбар зөвлөл байгуулах асуудлыг өнөөгийн удирдлагаас шийдвэрлүүлэхэд онцгой анхаарч ажилласан. Тухайлбал: гаалийн байгууллагад шаардлагатай буюу дутуу /ГТ-ангилалын/ 310 орон тооны хэрэгцээ хүлээгдэж байгаа тул салбар зөвлөлийг нэн яаралтай байгуулж сул орон тооны сонгон шалгаруулалт зохион байгуулж, хүний нөөцийн нөхөн хангалтийг шийдвэрлэх асуудлаа Сангийн яам, Төрийн албаны зөвлөлд удаа дараа танилцуулж ажилласнаар Сангийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг шилжүүлж ГЕГ-ын дэргэдэх “Салбар зөвлөл” байгууллаа.

Салбар зөвлөл байгуулагдснаар гаалийн байгууллагад үүссэн сул орон тоог нөхөн хангах ажлыг шуурхай явуулах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэшсэн, чадварлаг, хүний нөөцийг бүрдүүлэх боломж бүрдэж байна.

Сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг энэ оны 07 болон 10 дугаар саруудад 2 удаа зохион байгуулж хөдөө орон нутагт дутагдалтай албан тушаалд томилж нөхөв. Үүнд:

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон Шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгжээс тус байгууллагад шилжин орж ажиллахыг хүссэн төрийн жинхэнэ албан хаагчид материалаа цахим/-аар ирүүлэх <http://www.ecustoms.gov/>, Гаалийн байгууллагын төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэх албан тушаалын 60 ажлын байрны 180 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт явуулах захиалгыг энэ оны 06 дугаар сарын 21-ны өдөр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж тус байгууллагын <https://csc.gov.mn>-д зарыг байршуулж мэдээллийг олон нийтэд хүргэж шалгалтыг 07 дугаар сарын 20-ноос 21-ний өдрүүдэд шалгалтыг МУИС-ийн Бизнесийн сургууль дээр зохион байгууллаа.

Эхний зохион байгуулсан тусгай шалгалтад тэнцэж, сургалтад хамрагдсан 104, мэргэшлийн сургалтад хамрагдаагүй 51 иргэнийг гаалийн хэргийн мэдлэг олгох анхан шатны сургалтад хамруулан нийт 155 иргэнийг гаалийн байгууллагын албан тушаалд томиллоо.

Мөн энэ оны 9 дүгээр сарын 29-ны өдөр Гаалийн ерөнхий газар болон харьяа газар, хороодын 55 албан тушаалд хамаарах 106 сул орон тоонд тусгай шалгалтыг дээрх цахим хуудаст байршуулж зарласан.

Хоёр дахь тусгай шалгалтад 64 иргэн тэнцсэнээс сургалтад хамрагдсан 27 иргэнийг томилж, 37 иргэнийг сургалтад хамруулж Гашуунсухайт, Шивээхүрэн, Дорнод, Сэлэнгэ, Замын-үүд, Сайншанд зэрэг орон нутагт томиллоо.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн / 27.1.2 буюу сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагаас ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас орон тоог нөхнө / дагуу төрийн байгууллага хооронд шилжүүлэн авч болох нөхцөлөөр 15 албан хаагчийг гаалийн байгууллагад шилжүүлэн авч томиллоо.

Гурав дахь тусгай шалгалтыг энэ оны 12 дугаар сард зохион байгуулахаар Төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах зарыг 94 албан тушаалд хамаарах 165 сул орон тоонд шилжин ажиллах зарыг энэ оны 11 дүгээр сарын 27-ноос 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх 5 хоногийн хугацаанд www.ecustoms.gov.mn болон www.csc.gov.mn цахим хуудсаар олон нийтэд зарлаад ажиллаж байна.

Тусгай шалгалтад орж тэнцэн, гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох, чиглүүлэх сургалтад хамрагдаж буй иргэдийг төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулж тэнцсэн тохиолдолд томилж байна.

Гаалийн хяналт шалгалтын ажлын ачаалал, барааны эргэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан Улаанбаатар хот дахь гаалийн газар болон Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газраас 17 албан хаагчийг орон тоо дутагдалтай байгаа Сэлэнгэ, Гашуунсухайт, Шивээхүрэн дэх гаалийн газруудад түр хугацаагаар томилон ажиллуулахаар зохион байгуулалтын арга хэмжээ авч үүргээ гүйцэтгээд ирсний дараа хүлээн авч уулзаж, санаа сэтгэгдлийг сонгож тэмдэглэн Сэрп-д байршуулав.

Дөрөв. АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГАА ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох, гаалийн улсын байцаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ыг шинэчлэн батлуулах хэрэгцээ, шаардлагын талаар төсөл бэлтгэж, удирдлагад танилцуулж Хуулийн хэлтэст хүргүүллээ.

Төрийн захиргааны албан тушаалын ангиллыг гаалийн байгууллагын албан тушаалын ангилалтай дүйцүүлэн ойлгох зохицуулалтыг “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д тусгах боломжтой эсэх талаар зөвлөмж, чиглэл авахаар. энэ оны 11 дүгээр сарын 23-ны өдөр 01/4255 албан бичгээр Төрийн албаны зөвлөлөөс зөвлөмж, чиглэл хүсэж хүргүүллээ.

Холбогдох хууль, эрх зүйн актыг хэрэгжүүлэх хүрээнд шинээр томилогдож буй албан хаагчдаас “Хувийн мэдээллээ чөлөөтэй өгөх баталгаа”, туршилтын хугацаагаар томилогдож буй иргэдээс “Туршилтын хугацаагаар томилон ажиллуулахыг зөвшөөрөх эсэх тухай” баталгааны загварыг гарган, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Харьяа гаалийн газар, хороодын удирдлагуудад өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор албан тушаал, ажлаас чөлөөлөгдөж буй албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгуулахад шаардлагатай материалын жагсаалт, загвар хүснэгт боловсруулан энэ оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 01-1.1/4019 албан бичгээр хүргүүллээ.

Гаалийн ерөнхий газрын “Гаалийн улсын байцаагчийн цолны журам батлах тухай” А/295 дугаар тушаалын дагуу гаалийн ерөнхий газрын 76 албан хаагчид итгэмжит зөвлөхийн 45 хувь, 63 албан хаагчид гаалийн зөвлөхийн 40 хувийн нэмэгдлийг олгож, энэ оны 10 дугаар сарын 20-ны өдөр шинээр гаалийн итгэмжит цол -37, гаалийн зөвлөх цол-106 олгож цалин нэмэгдлийг шинээр олгохоор тооцууллаа.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 30 албан хаагчид зохих журмын дагуу 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тэтгэмжийг олгох шийдвэрийг бэлтгэн гаргав.

Нийт 79 албан хаагч, болон ар гэрийн гаргасан хүсэлтийн дагуу Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /550.000/ төгрөгийн тусламж олгож шийдвэрлүүлэв.

“Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.2-т заасны дагуу энэ оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 01-1.1/4020 дугаартай албан бичгээр харьяа гаалийн газар, хороодод журамд заасан шаардлага, шалгуур хангасан албан хаагчдад зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгуулах саналыг энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн бөгөөд саналыг нэгтгэж удирдлагад танилцуулахаар ажиллаж байна.

ГЕГ болон харъяа газар, хороодоос судалгаа /ЗУГ/ авч үйлчилгээний 67 ажилтанд нийт 36.8 сая төгрөгийн түлээ нүүрсний тусламж үзүүлсэн байна.

Албан хаагч өөрөө болон гэр бүлдээ эмчилгээний зардалд мөнгөн дэмжлэг хүссэн 6 хүсэлтийг СХОГ-т шийдвэрлүүлэхээр шилжүүлэв.

АХМАДЫН ХОРООТой ХАМТРАН АЖИЛЛАСАН ТУХАЙ :

“Ахмадын байгууллага, ахмадуудтай хамтран ажиллах”, “Ахмадын сан” байгуулж ажиллах журам-ыг шинээр боловсруулж ГЕГ-ын даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн А/290 дүгээр тушаалаар баталж мөрдөж ажиллаж байна.

Ахмадын хороо 2022 оны ажлын тайлангаа хэлэлцэж 7 ахмадыг Хүндэт гаальчин, Гаалийн ажилтны өдөр буюу 10 дугаар сарын 20-ны өдрийг тохиолдуулан Дархан гаалийн газрын 2 ахмад настанд “Хүндэт гаальчин” тэмдгээр тус тус шагнагдлаа.

Үндэсний Их баяр, наадмыг тохиолдуулан нэр бүхий 15 ахмад настны Төрийн дээд одон медиалаар шагнуулахаар материалыг Сангийн яаманд хүргүүлэв./Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргэгдсэн/

Жил бүрийн 10 дугаар сарын 01-ны өдөр “Ахмадын баяр”-ыг тохиолдуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлж, гаалийн байгууллагын нийт 491 ахмадын судалгаа, бүртгэлийг шинэчлэн СХОГ- болон харъяа газар, хороодод хүргүүлэв.

Ахмадын хорооноос уламжилсан хүсэлт, санал,тэтгэмж олгуулах асуудлыг удирдлагад танилцуулж шийдвэрлүүлж ажиллаа.Үүнд:

Энэ онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 27 /ТТ-20, ТҮ-7/ ажилтныг ахмадын тоо бүртгэлд хамруулж, хөдөө орон нутгаас харъяалал өөрчлөх-4, шинээр ахмадын бүртгэлд хамрагдах 2 хүсэлт ирүүлснийг удирдлагад танилцуулж журамд заасны дагуу шийдвэрлүүлэв. харин гаалийн байгууллагад ажиллаж байгаад төрийн өөр байгууллагад шилжин ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгон гарсан боловч гаалийн байгууллагын ахмадын харъяалалд хамрагдахаар хүсэлт гаргасан 2 ахмадад хариуг өгсөн.

Албан хаагчдыг шагнаж, урамшуулсан талаар:

Албан хаагчдыг шагнаж, урамшуулахаар энэ оны 7 дугаар сарын 11-ны өдрийн “Үндэсний их баяр наадам”-ыг тохиолдуулан энэ оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 01-1.1/1645, мөн жил бүрийн 10 дугаар сарын 20-ны “Гаалийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01-1/3142 албан бичгээр чиглэл хүргүүлж нийт 41 нэгжийн 479 албан хаагч, ажилтаны материалыг хүлээн авч, шийдвэрлүүлэн ажиллаа.Үүнээс: Үндэсний их баяр, наадмыг тохиолдуулан төрийн одон медальд-125

- Үйлчилгээний гавъяат ажилтан-1,
- Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон-12,
- Алтан гадас одон-22,
- Хөдөлмөрийн хүндэт медалиар 90, нийт 125 Төрийн одон медалиар шагнуулах саналтай материалыг ГЕГ-ын даргын мөн оны 06 дугаар сарын 19-ны 01/2290, салбарын шагналыг 10 дугаар сарын 03-ны 01/3530 дугаартай тус тус албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, салбарын шагналыг шийдвэрлүүллээ. /Төрийн одон медаль ЕТГ-т хүргэгдсэн/ мөн Хорио цээрийн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдыг чиг үүргийн хамааралтай тухайн салбарт уламжилж ЗУГ-ын даргын 10 дугаар сарын 10-ны өдрийн - 01/3593, 10 дугаар сарын 11-ны өдрийн 01-1/3614 албан бичгээр ХААХҮЯ-сайд, МЗХ-нд

тус тус хүргүүлэв. Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд: Сангийн яамны буюу Салбарын шагнал-76 буюу үүнээс:

- “Гаалийн албаны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 48,
- “Жуух бичиг”-ээр 28

Гаалийн байгууллагын шагнал-84

- “Хүндэт гаальчин” 23,
- “Жуух бичиг”-ээр- 61 буюу нийт 160 албан хаагч шагнагдлаа.

Гаалийн байгууллагад мэргэжлийн туслалцаа үзүүлж ажилласан бусад байгууллага ажилтныг мөн шагнаж урамшуулав. Үүнд:

-Дорнод аймагт гарсан ой хээрийн түймэрээс байгууллагын эд хөрөнгийг хамгаалахад техникийн туслалцаа үзүүлж хамтран ажилласан Милланж ХХК-д удирдлагаас “Дурсгал”- хүндэтгэл, оператор /жолооч/ Б.Батболдыг ГЕГ-ын Жуух бичгээр,

- Гаалийн хяналт шалгалтад хуулийн байгууллагатай хамтарсан Суваг-1 тусгай ажиллагааны хүрээнд ажилласан Эрүүгийн цагдаагийн газрын-1, Тагнуулын ерөнхий газрын -1 ажилтнуудыг ГЕГ-ын Жуух бичгээр,

-Цахим шинэчлэл хүрээнд хамтран ажилласан Сангийн яамны дэргэдэх Мэдээлэл технологийн төвийн улсын үйлдвэрийн газрын цахим хөгжүүлэгч, мэргэжилтэн нарын 3 ажилтныг ГЕГ-ын Жуух бичгээр тус тус шагнав.

Уг ажиллагаануудад эр зориг, ур чадвар гарган ажилласан Дорнод дахь гаалийн газрын үйлчилгээний ажилтан-1, ЧХОУНБГГ-ын нохой маллагч-1 ажилтнуудыг мөнгөн урамшуулал /нэг сарын үндсэн цалинтай тэнцэх/олгов.

Энэ оны 12 дугаар сарын 04-ны өдөр буюу Санхүү, эдийн засагчдын өдрийг тохиолдуулан гаалийн газар, хороодоос санал авч болзол хангасан 7 албан хаагч буюу Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан-2, Санхүү, банкны тэргүүний ажилтан-1, Сангийн яамны Жуух бичиг-4 тус тус шагнагдлаа.

Шагнал гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хөтөлбөр, дэг, шагнуулах албан хаагчдын төлөөллийг УБГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ-аас урьж оролцуулах нэрсийг гарган удирдлагад танилцуулж ажиллаа. Мөн харъяа газар, хороодыг тухайн цагт нэгэн зэрэг эхлүүлж зохион байгуулах чиглэл хүргүүлж зохион байгуулав.

Албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан тухай:

Хүний нөөцийн хэлтсээс 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөт ажлын хүрээнд алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг энэ оны 3 дугаар улиралд зохион байгууллаа.

Урьдчилан сэргийлэх үзлэгтэй холбогдон гарах зардлыг 2022 оны Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хязгаарласан тул 2024 онд зарцуулах төсвийн тооцооллийг гарган СХОГ-т хүргүүлэв.

МУ-ын Засгийн газрын тогтоолоор улс орон даяар зохион байгуулж буй “Эрт илрүүлэг”-ийн үзлэгт алба хаагчдыг хамруулж, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх

ажлыг явуулахаар 2023.07.28-ны 01-1.1/2704 тоот албан бичгээр харъяа газар, хороодод, мөн тус хэлтсийн №68-дотоод зурвасаар ГЕГ-ын нэгжүүдэд хүргүүлж дүнг 09 дүгээр сарын 25-нд ирүүлэхийг мэдэгдсэн.

Уг ажлын хүрээнд нийт ажиллаж байгаа 1695 албан хаагчийн үүнээс ЕГ-ын зохион байгуулалтын нэгж, дэргэдэх байгууллагын 189 албан хаагч буюу **83.26%** хувь, харъяа газар, хороод 1317 албан хаагч буюу **85.79%** хамрагдлаа үлдсэн 14% буюу 200 гаруй албан хаагч нь ажлын нөхцөл, томилолт, амралт, чөлөө, эмчийн хяналтад байдаг зэрэг шалтгаантай байна.

Үзлэгийн онош код, өвчлөлийн талаарх дүгнэлтийг гаргаж удирдлагад танилцуулахаар ИТУААА-ны эмч Цэрэндолгорт хүргүүллээ.

Тусгай шалгалтад тэнцсэн 243 иргэнийг Төрийн тусгай эмнэлэгт эрүүл мэндийн үзлэг хамруулж албан тушаалд томилж шийдвэрлэв.

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА:

Тус хэлтсийн төлөвлөгөөт ажлын хүрээнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхээр албан хаагчдын дунд сэтгэл ханамжийн судалгааг гүүглэ форм ашиглан явуулав. Судалгаанд нийт 852 албан хаагч оролцсон үүнээс 35,2 хувь нь 41-50 насныхан мөн 63,3 хувь нь эмэгтэй албан хаагч хамрагдсан.

Албан хаагчдын 94,4 хувь нь гаалийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэшүүлэх давтан сургалт зохион байгуулах хүсэлтэй ба үүнээс

- Мэргэшүүлэх сургалтын агуулгаар “Гаалийн үнэ, үнэлгээ”-ний чиглэлээр 31,6 хувь, “Гаалийн хяналт шалгалт”-ын чиглэлээр 27,5 хувь байна.

Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай шинээр мэдлэг олж авах буюу Хуулийн мэдлэг 61,7 хувь, “Гадаад хэл (англи, орос, хятад) хэлний мэдлэгийг шинээр олж авах шаардлагатай 48,1 хувь бол хариуцаж байгаа ажил үүргээ гүйцэтгэхэд “Мэдээлэл цуглуулах чадвар” 45.5 хувь, “Асуудал шийдвэрлэх чадвар”-ыг хөгжүүлэхийг 41,3 хувь дэмжсэн саналаа өгсөн байна.

Гаалийн ерөнхий газрын сургалтын чиг үүргийг Сургалтын төв хариуцах нь зүйтэй гэж судалгаанд оролцсон албан хаагчдын 85,6 хувь нь хариулсан байна. Иймд Сургалтын төв холбогдох зардлын саналыг төлөвлөх, сургалтын хөтөлбөр агуулга боловсруулж шийдвэрлүүлж ажиллах хэрэгтэй байна. Судалгааны дүнг СЭРП-ийн Хүний нөөцийн хэлтэс талбарт байршуулав.

Тав: ХУВИЙН ХЭРЭГ, ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ, АШИГЛАХ ТАЛААР

Гаалийн байгууллагын нийт албан хаагчын хувийн хэргийг ТАЗ-ын 2022 оны 600 дугаар тогтоолын 2-р хавсралт Төрийн албан хаагчийн анкетыг шинэчилж бүрдүүлэхэд журмын дагуу анхаарч ажиллаа.

Хувийн хэрэгт авагдаагүй буюу шинээр бүрдүүлэхээр гэмт хэрэгт холбогдолгүй, ял шийтгэлгүй талаарх тодорхойлолтыг и-монголиа системээс иргэний эрүүгий хариуцлага хүлээж байгаа эсэх тодорхойлолтыг гаргуулж хувийн хэрэгт нэмэлт материал үүсгэлээ.

Албан хаагчдыг сэлгэн ажиллуулах цахим аргачлалыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Гаалийн байгууллагын захиргаа, дотоод ажлын систем СЭРП-ийн АНКЕТ-хэсгийн цахим санд шинээр цэс үүсгэлээ. Үүнд:

- Ажлын үр дүнгийн дундаж үнэлгээ
- Гаалийн байгууллагад ажилласан байдал
- Тайлан судалгаа
- Шилжилт хөдөлгөөний тайлан
- Хүсэлт
- Үндсэн цэсэнд гэр бүлийн байдал, эрүүл мэндийн үзүүлэлт дэд цэс нэмэгдсэн.

ГЕГ-ын 24 нэгжийн 204 албан хаагчийн хувийн хэргийг СЭРП-д хянаж захиргааны акт тушаал, хөдөлмөр болон нийгмийн даатгалын дэвтэр бусад нотлох баримттай тулган баталгаажуулалтыг хийж дуусгав.

Гаалийн зөвлөх, гаалийн итгэмжит зөвлөх цол олгуулах саналтай ирүүлсэн 193 албан хаагчийн холбогдох материалд хэрхэн шийдвэрлэсэн талаар тэмдэглэл хийж, хувийн хэрэгт баяжилт болгон хийсэн. Мөн Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар шийдвэрлэгдсэн 149 албан хаагчийн холбогдох материалыг хувийн хэрэгт баяжилт болгон хийсэн.

Тус хэлтэст нийт 1500 гаруй төрийн албан хаагчийн хувийн хэрэг хадгалагдаж байна. Хувийн хэргийн хадгалалтын одоогийн нөхцөл нь нарны шууд тусгалтай, ажлын өрөө, халуун хуурай, зориулалтын бус шүүгээтэй, гялгар хавтаст хадгалагдаж байна. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль болон Хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилтийг зөрчих нөхцөл үүсгэсэн, зориулалтын стандартын өрөө гаргаж шилжүүлэх, цаасаар хадгалагдаж буй хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтын сайжруулах, зориулалтын өрөөг нэн түрүүнд шийдвэрлэх, түүнчлэн хувийн хэргийн хавтас, цоож бүхий зориулалтын нягтаршуулсан шүүгээ зэрэг шаардлагатай тоног төхөөрөмж мөн хувийн хэргийн баяжилт хөдөлгөөн, техник ажиллагаа хийх орон тооны саналаа удирдлагад танилцуулж СХОГ-т шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн боловч ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

Тусгай шалгалтаар гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороонд томилогдсон 100 албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын 1-р хавсралтын дагуу төрийн албан хаагчийн хувийн хэрэгт байх үндсэн бичиг баримтын жагсаалтыг танилцуулан хувийн хэргийг бүрдүүлэн авлаа. Тусгай шалгалтад тэнцэж албан тушаалд томилогдсон 104 албан хаагчийн хувийн хэргийн материалын баяжилт хийв.

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд ГЕГ-ын 227 албан хаагчдын цалин, нэмэгдэл, шилжилт хөдөлгөөн болон бусад мэдээллийг оруулж санг бүрдүүлэв. Мөн энэ онд 140 албан тушаалын дагуу ГЕГ-ын 250 гаруй албан хаагчдын мэдээллийг цахим системд мэдээлэлийг оруулав. Мөн гаалийн байгууллагад шинээр томилогдсон 243 албан хаагчийн цалин нэмэгдэл болон бусад мэдээллийг харъяалах гаалийн газрын ажилтан өөрт олгогдсон эрхээр нэвтрэн орж мэдээллийн санг үүсгэсэн байна.

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинчлэн тогтоох тухай” тогтоолын дагуу гаалийн ерөнхий газрын 251 албан хаагчийн үндсэн цалинг оруулахын зэрэгцээ 18 газар, хороод ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын цалингийн мэдээллийг шинэчлэн оруулах чиглэл зөвлөмж хүргүүлж ажиллав.

Нийгмийн даатгал, Татвар, Цалингийн системүүд ”Иргэний бүртгэлийн дугаар буюу CIVIL ID” ашиглаж эхлэж байгаатай холбогдуулан ГЕГ-ын 263 албан хаагчийн мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн ХНУМТ цахим системд ХУР-аас татан шинэчлэлт хийсэн.

Зургаа . ӨРГӨДӨЛ,ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР:

Хүний нөөцийн хэлтэст энэ оны байдлаар нийт 771 хүсэлт, өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс иргэнээс 135, ажилтнаас 636 өргөдлийг хянан хариу өгч ажилласан байна. Үүнээс шийдвэрлэсэн-752, судалж байгаа-19, шилжүүлсэн-21, өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх явцад хугацаа хэтэрч хариу өгсөн -1 байна.

Өргөдлийн агуулгаас харахад иргэнээс ирсэн өргөдөл хүсэлтийг ажилд орох тухай, ажилтны хүсэлт нь сэлгэн ажиллах болон чөлөө хүссэн, ажлаас чөлөөлөх, чөлөөний хугацаа дуусаад ажилдаа орох, тусламж, тэтгэмж хүссэн, тэтгэвэрт гарах хүсэлтүүд эзэлж байна.

Өргөдлийг хянах, судлах ажиллагаанд хуулийн хүрээнд баримт, үндэслэл, холбогдох чиг үүргийн нэгжээс санал авах, хүсэлт гаргасан иргэнээс нягтлан тайлбар авах, удирдлагуудад танилцуулах, шаардлагатай мэдээлэл цуглуулах, харъяалах нэгжээс санал авахаар тус хэлтээс 198 удаагийн дотоод зурвасаар хандаж хамтран судалж, шийдвэрлэж ажилласан байна.

Тус хэлтэст 622 албан бичиг байгууллагуудаас хуваарилагдаж ирсэн байна Эдгээрээс хугацаандаа шийдвэрлэсэн 579, шилжүүлсэн-40, хамтран шийдвэрлэсэн-2 нийт 93.04 хувийн шийдвэрлэлтийн хувьтай байна үлдсэн 6-7 хувь нь судлагдаж байна.

Долоо. ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР:

Гаалийн байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааны талаар ил тод байдлыг хангаж <https://www.customs.gov.mn/> цахим хуудсанд дараах мэдээллийг байршуулав. Үүнд: Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2023 оны А/32 дугаар тушаалын дагуу 2019 оны

Албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт хийж 1388 албан хаагчийн 140 ажлын байрны албан тушаалийн тодорхойлолтыг гаалийн байгууллагын цахим хуудас болон/ <http://www.ecustoms.gov/>-сайтад /байршуулав.

Гаалийн байгууллагын Салбар зөвлөлөөс зохион байгуулсан тусгай шалгалтын зар мэдээллийг тухай бүр тус хуудсанд байршуулж, мэдээллийг хүргэж ажиллаа.

Шилэн дансанд ГЕГ-ын бүтэц орон тоог сар бүрийн 08-ны дотор байршуулав.

Хүний нөөцийн чиглэлээр гаалийн байгууллагын цахим хуудсны мэдээлэлтэй танилцан хөгжүүлэх, нэмэлт цэс өөрчлөлт оруулах тухай санал бүхий танилцуулгыг бэлтгэж ЗУГ-ын даргад өгч ажиллав.

Найм. Ажлын цаг ашиглалт, албан томилолтыг бүртгэх, хянах талаар,

Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/226 дугаар тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын дотоод журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.3, 9.4 дэх заалтуудад албан хаагчдын цаг бүртгэлийг төхөөрөмжөөс нэгтгэн гаргаж, баримт болгон цалин хөлс олгоход ашиглахаар тусгасан. Захиргаа, дотоод ажлын систем (CERP) нь цаг бүртгэлийн талаарх мэдээллийг нэгтгэн гаргадаггүй нь албан хаагчдын цаг ашиглалтыг сар бүр дүгнэж, цалин хөлс олгож ашиглахад хүндрэлтэй байгаа тул цаг бүртгэлийн төхөөрөмжид сайжруулалт хийх талаар Мэдээллийн технологийн газарт дотоод зурвасыг энэ оны 08 сарын 24-нд хүргүүлсэн боловч тус нэгжийн ажлын ачааллаас болоод өнөөдрийг хүртэл хийгдээгүй байна.

Албан хаагчдын цаг бүртгэлийг харахад энэ оны эхний 10 сарын байдлаар нийт албан хаагчдын 6-19% нь цагаа бүрэн бүртгүүлж байгаа бол албан хаагчдын 11-31% нь ямар нэгэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр огт цаг бүртгэл хийлгээгүй байна. Нүүр таних төхөөрөмжид бүртгүүлээгүй тохиолдолд илүү цагийн хөлсийг олгохгүй байх зохицуулалт хийхээр судалж шийдвэрлүүлнэ.

СХОГ-тай хамтран 2023 оны 1, 2, 3 дугаар улиралд давхардсан тоогоор ГЕГ-ын нийт 359 албан хаагчид илүү цагийн тооцоог гарган өгч 268.3 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг олгох шийдвэрийн төслийг бэлтгэж өгч шийдвэрлүүлсэн.

Албан томилолтоор ГЕГ-ын 71 албан тушаалтан хөдөө орон нутагт албан ажлын шаардлагаар ажиллахаар СЭРП-д хүсэлт илгээж тус нэгжээс хянаж баталгаажуулав.

ГЕГ-ын албан хаагчид энэ оны ээлжийн амралтыг биеэр эдэлсэн 225, ээлжийн амралтаа эдлээгүй буюу амраагүй 29, үүнээс харъяа газар, хорооны дарга-2 байна.

Нүүр таних төхөөрөмжөөр ажилтны цаг бүртгэлийг хянаж байгаа талаар Мэдээллийн технологийн газарт 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 76 дугаар дотоод зурвасаар Гаалийн захиргаа, дотоод ажлын систем (CERP)-д цаг бүртгэлийг автоматаар мэдээллийг татах боломжтойгоор системийн сайжруулалтыг хийх, 2023 оны

10 дугаар сарын 13-ны өдрийн 130 дугаар дотоод зурвасаар цаг бүртгэлийн системээс ажлаас чөлөөлөгдсөн 13, тэтгэвэрт гарсан 3, өөр ажилд шилжин томилогдсон 3, жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй 4, нийт 23 албан хаагчийн хасууллаа. Мөн шинээр ажилд томилогдсон албан хаагчдыг цаг бүртгэлийн системд тухай бүр бүртгэн ажиллалаа.

Жендерийн тэгш байдал хангах:

Энэ оны 06 дугаар сарын 23-ны өдөр Жендерийн үндэсний хорооны сургагч багш Б.Наранцацралтыг урьж Жендерийн тэгш байдал сэдэвт мэдээлэл сургалтыг ГЕГ-ын 9 давхарын хурлын зааланд хийв.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон хөгжлийн зорилтот хөтөлбөр, жендерийн үндэсний хороо, салбар зөвлөлөөс зохион байгуулж буй ажлыг хэрэгжүүлэн ажиллах Гаалийн байгууллагын Жендерийн дэд салбар зөвлөлийг ГЕГ-ын даргын 2023 оны 11 сарын 22-ны өдрийн А/537 дугаартай тушаалаар байгууллаа.

Хүний нөөцийн мэдээллийн сангаас Жендерийн тухай хуулинд заасан хүйсийн харьцааг албан тушаалаар удирдах, гүйцэтгэх гаргах боломжтой буюу мэдээллийн сантай болно. Уг сангаас 2023 оны жендэрийн судалгааг гаргаж Сангийн яамны Жендэрийн хорооны ажилтан Болормаад файлаар хүргүүлэв./Файл хавсаргав/.

Жендерийн үндэсний хорооноос 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайлан”-гийн танилцуулга, салбар дундын бодлого зохицуулалтын хүрээнд мэдээлэл солилцох зорилго бүхий уулзалтад Жендэр хариуцсан албан хаагч оролцлоо.

Тус уулзалтаар Сангийн яамны дэргэдэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн тайланг сонсож, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцлоо.

Ес .Сургалт хөгжил, судалгаа, лавалгааны талаар:

Тус нэгжийн удирдлага болон ажилтнууд 2023 онд дараах сургалтад хамрагдлаа. Үүнд:

Энэ оны 3 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн танилцуулгад Хүний нөөцийн хэлтсийн дарга Ж.Баясгалан, ГУБ Ч.Чимэд-Очир, ГУБ Ө.Тэгшээ нар.

Мөн 05 дугаар сарын 16-ны өдөр Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан НҮБ-ын аюулгүй Зөвлөлийн “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудлаарх 1325 дугаар тогтоол”-ыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө(ҮҮАТ) боловсруулах, салбар дундын ажлын хэсэг байгуулах асуудлаар санал солилцох уулзалтад Хүний нөөцийн хэлтсийн дарга Ж.Баясгалан, ГУБ Ч.Чимэд-Очир,

ЗГХЭГ-аас зохион байгуулж буй "Төрийн албан хаагийн гүйцэтгэлийн үнэлгээний журам"-ын төслийг танилцуулах, санал солилцох хэлэлцүүлэгт Хүний нөөцийн хэлтсийн дарга Ж.Баясгалан, ГУБ Ч.Чимэд-Очир нар,

БНСУ-ын Чеонан хотноо 2023 оны 9 дүгээр сарын 11-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан БНСУ-ын гаалийн байгууллагын харьяа Гаалийн хүний нөөцийн хөгжлийн институтийн 15 дахь удаагийн “Олон улсын гаалийн байцаагч нарын хүний нөөцийн хөгжил” семинарт хэлтсийн дарга Ж.Баясгалан хамрагдсан.

Удирдлагын академиас зохион байгуулсан “Чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сэдэвт 5 хоногийн сургалтад энэ оны 10 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд ХНХ-ийн дарга Ж.Баясгалан, ГУБ Б.Мөнхтуул нар танхим, цахим хосолсон хэлбэрээр хамрагдаж, сертификат авсан.

Төрийн албаны зөвлөлөөс пүрэв гариг бүр зохион байгуулдаг “7:4:10” сургалтад тус хэлтсийн албан хаагчид тухай бүр нь хамрагдаж байна.

Хүний нөөцийн үйл ажиллагаанд ашиглахаар 75 төрлийн судалгаа гаргаж удирдлагыг мэдээллээр хангаж ажиллалаа. Тухайлбал:

- Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газарт батлагдаагүй илүү орон тоонд ажиллаж байгаа 39 төрийн үйлчилгээний албан хаагчийн судалгаа
- Хилийн боомтод 1-5 жил тасралтгүй ажиллаж байгаа албан хаагчдын судалгаа. /14 газар, хороо 830 ТТ албан хаагч буюу 61.5%, гүний гаальд 50 албан хаагч 3,7%/
- Хорио цээрийн албанд 10 жилээс дээш жил ажилласан 165 албан хаагчдын судалгаа
- Гаалийн ерөнхий газрын дэргэдэх сургалтын төвөөс ирсэн 38 дугаар дотоод зурвасын дагуу Гааль, эдийн засгийн дээд сургуулийн бакалавр, магистр төгссөн 130 /давхардсан тоогоор/ албан хаагчдын судалгаа
- Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсээс 2023.08.25-ны өдөр ирүүлсэн №607 тоот зурвасын дагуу төрийн тусгай шалгалтад тэнцэж, гаалийн байгууллагад шинээр томилогдсон эрх зүйч мэргэжилтэй 22 албан хаагчийн дэлгэрэнгүй судалгаа
- Гаалийн газар, хороодын хяналтын бүс /160 хяналтын бүсэд 692 албан хаагч/ болон бичиг баримтын бүрдүүлэлт /29/, хяналт шалгалтын /601/ чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчийн судалгаа
- Гаалийн байгууллагын удирдах албан тушаалын сул орон тоо /8/болон түр орлон гүйцэтгэгч нарын судалгаа /44/
- ГЕГ-ын харьяа 18 газар, хороодын илүү 80 орон тооны судалгаа
- Гаалийн зөрчилтэй, тэмцэх аюулгүй байдлын газраас ирүүлсэн 672-р дотоод зурвасын дагуу Гаалийн ерөнхий газрын дарга болон дэд дарга, Гашуунсухайт дахь гаалийн газар, Шивээхүрэн дэх гаалийн газар, Замын-Үүд дэх гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Ховд аймгийн Булган дахь гаалийн газар, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн газарт 2008-2022 оны /5 жил/ хооронд ажиллаж байсан албан хаагчдын судалгаа
- Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газарт батлагдаагүй илүү орон тоонд ажиллаж байгаа 39 төрийн үйлчилгээний албан хаагчийн судалгаа

- Гаалийн байгууллагын орон тооны мэдээг улирал бүр гарган Статистик, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлэв.
- Гаалийн ерөнхий газар болон харьяа газар, хороодоос жендерийн судалгааг авч нэгтгэн Сангийн яаманд хүргүүлээ.

Харьяа газар, хороодын захиргаа хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудад өгсөн сургалт, зөвлөмжийг өгч ажиллаа. Тухайлбал:

Энэ оны 03 дугаар сарын 24-ний өдөр ГЕГ-ын 9 давхрын хурлын зааланд харьяа гаалийн газар, хороодын захиргаа, хүний нөөц хариуцсан албан хаагчидтай хүний нөөц, дотоод ажлын талаар сургалт, уулзалтыг зохион байгуулсан. Тухайлбал, Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн шинэчлэлтэй холбоотой Өндөр насны тэтгэвэрт гарах албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг Тэтгэмж цэсэд хэрхэн нэмэх талаар мөн ажлаас халагдсан, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, тэтгэвэрт гарсан албан хаагчдын мэдээллийг оруулах, албан хаагчдын улсад болон төрд ажилласан жилийг ЗДАСП-тай хэрхэн тулган шалгах талаар сургалт мэдээлэл хүргүүлсэн.

“Шилжүүлэн ажиллах журам”-ын дагуу программ хийгдэж байгаатай холбогдуулан СЕРП-ын хүний нөөцийн дэд цэсийн цахим хувийн хэргийн баяжилтыг хийх талаар Улаанбаатар хот дахь ГГ, Улс хоорондын шуудан илгээмжийн ГГ, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь ГГ, Гашуунсухайт дахь гаалийн газрын захиргаа, хүний нөөц хариуцсан албан хаагчдад 9 дүгээр сарын 15-нд танхимын сургалтыг, мөн бусад газар, хорооны албан хаагчидтай цахимаар холбогдон заавар, зөвлөгөөг өгч ажилласан.

Удирдлагын академи нь энэ оны төрийн албаны мэргэшүүлэх сургалтад гаалийн байгууллагаас 8 албан хаагчийг төрийн зардлаар суралцахыг ирүүлсэн. Ингээд ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа газар, хороодоос Удирдлагын академийн 2023 оны мэргэшүүлэх багц сургалтад хувийн зардлаар хамрагдах албан хаагчдын судалгааг авч Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд нийт 165 албан хаагчийг сургалтад хамруулахаар албан бичгийг хүргүүлсэн. Үүний үр дүнд эхний ээлжинд буюу намрын элсэлтээр богино дунд хугацааны мэргэшүүлэх сургалт-3, ахлах түшмэлийн сургалт-24, эрхэлсэн түшмэлийн сургалт-6 албан хаагчтай гэрээ байгуулан суралцаж байна.

Арав . Цаг үеийн шинжтэй бусад томоохон ажлын талаар :

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 дугаартай албан бичгээр 11 чиглэлд арга хэмжээ авч ажиллав. Үүнээс:

Гаалийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгөөгүй 60, тусгай шалгалт өгөөгүй 88 албан хаагч нийт нийт 149 албан хаагчийг нөхцөл байдлыг тогтоосон.Тус албан хаагчдыг ажлаас чөлөөлж шалгалтад бэлтгэж, хамруулах ажлыг дэс дараатай зохион байгуулж одоогоор 107 буюу 71.8 хувь нь хууль ёсны томилогдов/

Албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлага буюу мэргэжил, мэргэшил, туршлага, боловсролын шаардлага хангасан албан тушаалтнуудыг мөн 2019 оноос хойш хугацааг хамруулсан байдлаар судалгааг гаргав.

Авлигатай тэмцэх газраас ашиг сонирхлын зөрчилтэй байдал тогтоогдсон зөрчил үүсэх нөхцөлтэй томилсон албан хаагчийн судалгаа хийхэд албан тушаалд томилох, сэлгэн ажиллуулахдаа албан хаагчийн ХАСУМ-хянуулсан байдалд АТГ-аас 2019-2022 оны ирүүлсэн дүгнэлтэд судалгаа хийж, 25 албан хаагч дээр ирүүлсэн дүгнэлтэд холбогдох тайлбар, лавлагаа гаргууллаа мөн 5 албан хаагчид сахилгын арга хэмжээ авч албан тушаал бууруулан сэлгэн ажиллууллаа.

Мөн 2019-2022 онд “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулаагүй томилогдсон давхардсан тоогоор 462 албан хаагчийн судалгаа гаргалаа.

Авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлсэн эсэх судалгааг гаргав. Үүнээс Гаалийн байгууллагад ажиллаж буй нийт 1445 албан хаагчдаас иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан болон байгаа эсэх талаарх судалгааг авч нэгтгэн үзэхэд Эрүүгийн хариуцлага хүлээж байсан-33, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа-5, хуулийн байгууллагад шалгагдаж байж болзошгүй 13 албан хаагчийн судалгааг гаргасан энэ мөрөөр ГЕГ-ын даргын “Чиглэл хүсэх тухай” 01/1285 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон Төрийн албаны зөвлөлд хандсан. Энэ тухайд Төрийн албаны зөвлөлийн 2023.05.17-ны 03/1145 тоот албан бичгээр тус зөвлөлөөс дараах чиглэл ирүүлээд байна энэ тухай Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ хэрэгжиж эхэлсэн буюу 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших хугацаанд Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэм бурууг шүүх тогтоож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон нөхцөлд төрийн жинхэнэ албан хаагчийг хуульд нийцүүлж албан тушаалаас нь халах зохицуулалттай тухай хариуг ирүүлсэн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийтлэг хэм хэмжээг удаа дараа зөрчсөн нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр тогтоогдсон зэрэг судалгааг гаргахад гаалийн байгууллагын хэмжээнд 2022 онд нийт 106 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан ба үүнээс тухайн жилдээ 2 удаа сахилгын шийтгэл хүлээсэн 3 албан хаагч байна.

Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага, мэргэжил тохирч байгаа эсэх судалгааг гаргахад албан тушаалын тусгай шаардлагад огт байхгүй 8 төрлийн мэргэжлийг гаргаж “Төрийн албаны зөвлөл”-д чиглэл авах зэргээр дээрх ажлын хүрээнд Засгийн газар, Сангийн яам, Төрийн албаны зөвлөлд танилцуулж хамтран ажиллаа.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас ажлын хэсэг ирж дээр шүүр ажиллагааны үр дүнг нягтлах, шалгах зорилгоор ГЕГ-дээр 15 хоног ажиллав. Уг ажлын хэсэгт мөн нийт албан хаагчдын хувийн хэрэгт авагдсан материалыг ГЕГ-ын нийт ажилтнууд болон харъяа газар, хороодын удирдлагуудын хувийн хэрэг болон захиргааны шийдвэрүүдэд үзлэг хийв.

Авилгатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, УИХ-ын хяналтын түр хороо, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Ажлын хэсгүүдэд ажлын шаардлагаар албан хаагчдын хувийн хэрэгт авагдсан материалыг хуулбарлах, танилцуулга мэдээлэл бэлтгэх, албан тушаалын тодорхойлолт, ажилд томилогдсон чөлөөлөгдсөн тушаал, үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг олон тооны материалыг баримт бичгийн шаардлага хангуулж баталгаажуулан хүргүүлж ажиллаа. Үүнд: Гашуунсухайт, Шивээхүрэн гаалийн газрын 2010-2022 онд ажиллаж байсан дарга, албаны дарга, ГУАБ, ГУБ, ГЕГ-ын 2004-2023, 2015-2022 онуудад ажиллаж байсан дарга, дэд дарга, удирдлагын зөвлөлийн гишүүд, Замын-Үүд, УБГГ, ЧХОУНБ гаалийн газрын нэр бүхий гаалийн улсын байцаагч нарын талаар судалгааг гаргаж өгөв.

Хувийн хэрэгт авагдсан материалыг бүрдүүлэхээр байгууллага, тухайн харъяа газар, улсын архиваас бүрдүүлэх замаар ачаалалтай ажиллав. Тухайлбал хамрах хугацаа, албан тушаалтан бүрээр дээр дурдсан материалыг 1 хүнд 7-25 хүртэл хуудас нийт 200 гаруй хүнд 3000 гаруй хуудастай материалыг хуулбараар хүргүүлсэн байна.

Арван нэг. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хүний нөөцийн хэлтэс зохих түвшинд ачаалалтай ажиллаа.

Тус хэлтэс 5 гаалийн улсын байцаагчийн орон тоотойгоос 2 чөлөөлөгдөж, 2 томилогдсон. /Ч.Чимэд-Очир, С.Содгэрэл нар чөлөөлөгдсөн, шинээр Б.Мөнхтуул, Б.Итэшмаа нар томилогдов/

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Төрийн албаны зөвлөл, Сангийн яам, Эрүүгийн цагдаагийн газар, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн нийт газар хороог хамарсан судалгаа зэрэг цаг хугацаа шаардсан үүрэг даалгаврууд нь АЧААЛАЛ өгч, илүү цагаар ажиллах шаардлагыг бий болгож байлаа.

Гаалийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлт, сул орон тоог нөхөх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, төлөвлөх, зохион байгуулах ажлыг дэс дараатайгаар НӨХӨН ХАНГАЛТ-хийх ажил амжилттай хэрэгжиж байна.

Албан хаагчдыг шилжин ажиллуулах ЦАХИМ АРГАЧЛАЛ-ыг боловсруулж батлуулахад тэдний оролцоог хангаж ажлын хэсэгт төлөөлөл оролцуулж ажиллуулсан явдал нь өөрсдөө нөхцөл байдлаа гаргах, тодорхойлох, асуудлыг шийдвэрлүүлэх боломжийг олгосон ажил болсон.

Гаалийн байгууллагын алба хаагчийн сургалт, хөгжил, гүйцэтгэлийг сайжруулах, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, амь насыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, ажиллах таатай орчноор хангах хүний нөөцийн хөгжлийн дунд хугацааны ХӨТӨЛБӨР-ийг боловсрууллаа.

Албан хаагчдыг шагнах, урамшуулах цол олгох ажлыг бодитой ШУДАРГА явуулж цаашид сайжруулах шаардлагатай МЭДЭЭЛЭЛ, анхааруулгыг харьяа газар, хороодод албан бичгээр хүргүүлэв.

Гаалийн байгууллагаас халагдсан чөлөөлөгдсөн албан хаагчийн гомдлыг хуулийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн ажилд нь эргүүлэн томилж байгаа нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр ЭРМЭЛЗЭЖ байна.

Цаашид захиргаа, хүний нөөцийн чиглэлийн ажилтнуудыг томилох, сургаж бэлтгэх, мотивацижуулах, тогтвортой ажиллуулахад анхаарч энэ чиглэлээр арга хэмжээг зохион байгуулж ажиллана.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС